



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/275

Хэрлэн сум

Мал амьтны гоц халдварт өвчин
бүртгэгдсэн сум, тосгонд ажиллахад зориулж
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.13, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт өвчний дэгдэлт буурахгүй байгаатай холбогдуулан мэргэжлийн удирдлагаар хангах, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, ажлын үр дүнг сайжруулах ажлыг зохион байгуулсугай.

2. Мал амьтны гоц халдварт өвчин бүртгэгдсэн Дадал, Баян-Адарга, Өмнөдэлгэр сум, Хэрлэнбаян-Улаан тосгонд ажиллах ажлын хэсэг байгуулан удирдамж гарган ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3. Гамшгийн эрсдэлийг бууруулах ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах тээврийн хэрэгслийн шатахууны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Хөрөнгө зарцуулалтад шаардагдах 375,600 (гурван зуун далан таван мянга зургаан зуун) төгрөгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 18-ны өдрийн
АКЗ захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д	Сумын нэр	Туулах зам /км/	Шатахуун ДТ	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	Хэрлэн-Баян-Адарга	170	34	3130	106420
2	Баян-Адарга-Дадал	85	17	3130	53210
3	Дадал-Баян-Адарга	85	17	3130	53210
4	Баян-Адарга-Хэрлэнбаян-Улаан	90	18	3130	56340
5	Хэрлэнбаян-Улаан-Өмнөдэлгэр	50	10	3130	31300
6	Өмнөдэлгэр-Хэрлэн	120	24	3130	75120
	Нийт	600	120		375600